

Регистрийн дугаар 2708701, Улсын бүртгэлийн дугаар 9019015031

**ГАДААДЫН ИРГЭН, ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙН НЭГЖ
БАЙГУУЛЛАГАД ГАЗАР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ**

2014 оны 09 сарын 06

Завхан аймаг Дөрвөлжин сум

Нэг.Нийтлэг үндэслэл

Монгол улсын Газрын тухай хууль, Завхан аймаг /нийслэл/-ийн Дөрвөлжин сум /дүүрэг/-ийн Засаг даргын 2012 оны 12 сарын 13-ны өдрийн 98 тоот шийдвэрийг үндэслэн газар өмчлөгчийг төлөөлж Дөрвөлжин сум /дүүрэг/-ийн газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан Хоролдорж овогтой Сувд-эрдэнэ, Газар ашиглагчийг төлөөлж Баян Айраг Эксплорэйшн ХХК-ны гүйцэтгэх захирал Виллиам Томас Колвин нар энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээнд гэрээний салшгүй хэсэг болох дараах зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дутуу бол гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно. Үүнд:

- 1.1. Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастрын зураг
- 1.2. Газар өмчлөгчөөс газар ашиглагчид тус газрыг хүлээлгэн өгсөн тухай акт
- 1.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг зохих журмын дагуу хийлгүүлж баталгаажуулсан баримт

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Газар ашиглагчид олгосон газрын нийт хэмжээ 2856,65 /га/. Үүнээс:

	Нэгж талбарын тодорхой хэсгийн ашиглах зориулалт	Га тутмын төлбөрийн хэмжээ /мян төг/	Тухайн зориулалтаар ашиглах газрын хэмжээ /га/	Газрын төлбөр /мян төг/
1	Уурхайн эдэлбэр газар	160.0	589.8	94368.0
2	Барилга байгууламж	40.0	137.25	5490.0
3	Уурхайн нөөц талбай	2.4	2129.6	5111.04
	Нийт		2856.65	104969.04

Талууд

А. Н. - 24



2.2. Газрын төлбөрийн хэмжээ

Нэгжийн үнэ: 160000 төгрөг, 40000 төгрөг, 2400 төгрөг

Бүгд үнэ: 104969040 төгрөг

/нэг зуун дөрвөн сая есөн зуун жаран есөн мянга дөчин төгрөг/
/үсгээр/

1-р улирал 26242260 төг

2-р улирал 26242260 төг

3-р улирал 26242260 төг

4-р улирал 26242260 төг

2.3. Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор тэнцүү хэмжээгээр Төрийн сан банкны 090500995 тоот дансанд шилжүүлнэ.

/Банкны салбарын нэр, дансны дугаар/

2.4. Газар ашиглуулах тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гаргасан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тогтооно.

2.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинэчилж тогтоолгоогүй бол зохих зардалыг газар ашиглагч хүлээнэ.

Гурав. Газар ашиглагчийн эрх үүрэг

3.1. Гэрээнд заасан нөхцөлийн дагуу газрыг ашиглах.

3.2. Газар өмчлөгчөөс газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг гаргуулж авах.

3.3. Гэрээнд үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн ашиглахаар эрхийн гэрчилгээний хугацааг сунгах.

3.4. Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь төлөх.

3.5. Газрын төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх.

3.6. Газар өмчлөгчөөс газар ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх.

3.7. Газрын кадастрын зураглалыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж баталгаажуулах.

3.8. Энэхүү гэрээний 2.1-д заасан зориулалтын дагуу уг газрыг ашиглах.

3.9. Холбогдох хууль тогтоомжоор тогтоогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх.

Х. А-Ч

Талууд

